

“ЧОНЫН ХӨӨЛГӨ” БА ӨНӨӨГИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Л. ЧУЛУУНБААТАР

Товч утга: Энэ өгүүлэлд байгаль хамгаалах өргөн хүрээтэй үйл хэргийн нэг хэсэг болсон ан амьтныг танин мэдэх, ашиглах, хамгаалах асуудлаас түүхэн уг үндэстэй холбогдуулан авч үзэж, танин мэдэхүйн болон практик ач холбогдолтой гэж хэлж болох зарим санааг илэрхийлсэн юм. Байгаль хамгаалал бол хүн төрөлхтөн өөрөө өөрийгөө хамгаалж байгаа хэрэг учраас өнөө үед энэ асуудалдонцгой анхаарахгүй аваас хэзээ ч нөхөгдөшгүй гарзхохирол тохиолдох магадлалтай гэдгийг хэн бүхэн сайн мэдэж байгаа билээ. Гэвч яагаад энэ асуудалд мэдсэн ч мэдээгүй юм шиг, ойлгосон ч ойлгоогүй байдлаар хандаж байна бэ хэмээгээд үндсэн асуудалдаа орьё.

Түлхүүр үг: Араатан, агналт, мөхөл, аврал, хамгаалал

Оршил

Манай гарагийн амин мандлын салшгүй нэг хэсэг нь амьтны аймаг (Animalia) юм. Энэ тогтолцоо нь асар урт удаан хугацаанд амьдралын нөхөн үржихүйн хуулиар үүсэл, хөгжилт, мөхөл сүйрэл гэсэн тодорхой үе шатыг туулан ирсэн түүхтэй байна. Гэвч хүний бодлогогүй, харалган үйл ажиллагаанаас шалтгаалж, амьтны аймгаас маш олон төрөл, зүйл устаж үүрдалга болсон байдаг. Энэ нь хүн төрөлхтөн өөрөө өөрийгөө хөнөөж байгаа хэрэг гэдгийг хүмүүс их хожуу ухаарч, хайрлах, хамгаалах үйл хэрэг их сүүл үед тавигдсан эмгэнэлтэй дүр төрхийг тодорхой харуулсан бус уу гэж хэлэх бодит үндэслэлтэй билээ. Хүн өөрөө байгалийн бүтээгдэхүүн атлаа байгалиас хүртэх нь их, өгөх нь бага болохоор байгаль хүнээс хариугаа авч, өдгөө манай дэлхийн хүн амын хүнсний хангамж тийм ч их биш, гамшигт үзэгдэл тохиолдох нь бүр олон болжээ. Энэ бол дэлхий нийтийг хамарсан асуудал болсон.

Далай тэнгисээс алслагдсан, эх газрын эрс тэс уур амьсгалтай, Ази тивийн өндөрлөг хэсэгт орших Монгол орон бол манай дэлхийн салшгүй нэг хэсэг, ан амьтны нөөц сайтай, баян тансаг өв уламжлалтай улс байлаа. Тийм ч учраас америкийн судлаачид монголыг Ази тивийн амьд амьтны өлгий гэж санал дэвшүүлж, үлэг гүрвэлийн мөрөөр уйгагүй мөрдөж, судалгааны санал дүгнэлтээ батлахыг ихэд хичээж иржээ. Нэн эртний аварга амьтдын араг ясны үлдэгдэл асар олон тоотой олдож, монгол орон бүхэлдээ байгалийн гайхамшигт эрмитаж болж, дэлхий дахины анхаарал, сонирхолд аль хэдийн орсон боловч бид бүхний хувьд онцгой анхаарах асуудал чамгүй байгаа билээ. Энэ нь ан амьтныг хайрлан хамгаалахтай шууд холбогдож байна. Энэ удаа чоно гэдэг хийморлог амьтны

тухайд товч өгүүлэхийг зорьсон болно.

Эрт дээр үеэс манай нутаг дэвсгэрт оршин амьдрагсад хурдан морь унаж, урт дэнзэн ташуур барьж, хээрийн амьтан буюу чоно хөөж агнаж ирснээс “ чонын хөөлгө ” гэсэн нэр томъёо гарч, харин одоо л энэ нэр томъёо мартагдаж байх шиг санагддаг. “ Буу зэвсэг ховор байх үед чоныг өвлөөс бусад цагт сайн мориор тал хээрийн бүсэд хөөж агнах явдал их дэлгэрчээ. Чоныг хөөж агнахад шивхэнсэн сайн морьтой бол нэг хүн ч хөөгөөд алж болно. Хэд хэдэн морьтой хүмүүс чоныг үргээн босгоод бүгдээрээ буюу өртөөлж хөөж агнах нь илүү амархан байдаг. Чоныг хөөж явахдаа түр зуур боловч амрааж болохгүй. Чоно амрах тутам улам хурдалдаг. Түүнчлэн хөөж яваа хүмүүс орилж хашгирахгүй чимээгүй явбал чоно байн байн гэдрэг эргэн харж явдаг учир түүндээ хүч нь саарч давхих нь муудна. Хөөж яваа чоноо гүйцэж очихын хамт урт ташуур буюу модны үзүүрт сур уяж борвиор нь дахин дахин сайн ороолгох хэрэгтэй. Тэгэхэд хүч чадал нь бүр муудаж явж чадахаа болиод хэвтээд өгдөг” гэж С. Лувсан бичсэн байна¹.

Чоно (wolf, Canis) Чонынхон (Canidae) овгийн төрөл. Саарал чоно (С. Lupus) гэрийн нохойны өвөг юм. Саарал чоно урьд нь хүнээс бусад бүх хөхтний зүйл дунд хамгийн өргөн тархсан зүйл байсан. Харин одоо үндсэндээ Канад, Аляск, Балканы хойг, Монгол, Орост тархсан. Чоно ухаалаг, хамтач амьтан. Үндсэн ан олзнь буга, хандгай, цаа буга болохын зэрэгцээ олон зүйлийн жижиг амьтнаар идэшлэдэг. Чоно гэрийн мал руу дайрдаг тул малчид, фермерүүд агнаж устгасаар ирсэн. Азарган саарал чонын биеийн урт 2 м, жин 80 кг хүрнэ. Чонын овгийн зэрлэг зүйлүүдээс хамгийн том биетэй нь саарал чоно юм. Саарал чонын сүрэг шатлан захирах ёстой бөгөөд 100 ам км — ээс доошгүй нутаг дэвсгэрийг хамарна. Шөнийн цагаар голдуу ангуучилна. АНУ-ын төв нутгийн өмнөд хэсгээр өргөн тархаж байсан нэлээд жижиг биетэй улаан чоно (С. rufus) —ыг хүний эрхшээлд өсгөн үржүүлж, нутагшуулж ирсэн. Этиопоос гаралтай абиссины чоно (С. simensis) —ыг урьд нь шагал чоно гэж тооцдог байв. Чонынхон (canine, canid, canidae) Гэрийн буюу зэрлэг нохой, нохойтой төстэй хөхтний зүйлүүдийг (жишээ нь чоно, шагал чоно, үнэг) багтаасан мах идэштний овог. Антарктид, далайн ихэнх арлаас бусад газар тархсан. Ерөнхийдөө гуалиг биетэй, урт хөлтэй, урт хоншоортой, сагсгар сүүлтэй, соотон чихтэй, сайн хөгжсөн араа, соёотой. Бүх төрлийн амьтнаар идэшлэнэ. Чоно нь гэршүүлсэн анхны амьтан байх магадлалтай. Мэрэгч, молтогчны тоо толгойг зохицуулахад тустай хэдий ч арьс үсийг нь авахын тулдагнадаг. Түүнчлэн мал аж ахуй, томоохон ан агнуурын нөөцөд хохирол учруулдаг (заримдаа үнэхээр хохирол учруулдаг) хэмээн агнаж устгасаар иржээ².

Манай орны хээрийн бүсийн чоно зэгэл саарал зүстэй байхад хангайн чоно нэлээд биеэрхэг, бараавтар сортой, толгойн уртын хагастай тэнцэх урт чихтэй, харах,

¹ Лувсан С, *Монгол анчны тэмдэглэл*, УБ, 1986, 61- 62.

² *Britannica Монгол хураангуй толь* (наадам- Яхь нуур) II, УБ, 2012, 713.

сонсох, үнэрлэх эрхтний хөгжилт маш сайтай амьтан юм.

1. Чоно бол амьд байгалийн санитарч буюу ариутган цэвэрлэгч.

Нохойн язгуурын багт хамаарагдах хүчирхэг, чийрэг араатан болох чоно европ, азийн орнууд, хойд америкийн нутагт өргөн тархсан байв. Гэвч европын зарим орнуудад чоно устгагдсан байна. Тухайлбал, Англи улсад 1910 онд хамгийн сүүлчийн чоноо алаад, чононд зориулсан хөшөө босгосон болов ч хэдэн жилийн дараа гадаадаас чоно худалдаж авсан гэдэг. Яагаад?

Байгалиас заяасан бүхэн өөр хоорондоо үлэмж шүтэлцээ бүхий, бас байгалийн шалгарлын хуулиар зохицуулагдаж байдаг жамтай. Тиймээс байгальд байгаа араатан амьтад энэ бичигдээгүй хуулийн үйлчлэлийн дор захирагдаж, аль хүч чадалтай нь үлдэж, хөгширсөн болон эрэмдэг зэрэмдэг нь ширвэгдэж ирсэн ажээ. Бидний өгүүлж буй чоно ч гэсэн амьдралын энэ алтан хуульд захирагдаж, хүч чадал, заль сүүхээгээрээ оршин амьдарч иржээ. Чоно бол байгалийн эко орчинд халдвартай болон халдваргүй өвчин эмгэгээр үхсэн амьтдын сэг зэмийг хүчирхэг эрүүнд бат бэхлэгдсэн 42 хүчирхэг шүдээр³ идэж, байгалийг цэвэрлэж байдаг. Иймээс хүмүүс чонын ходоодшиг хэмээн элдэв зүйлийг халуун, хүйтнээр нь идэж, сайн шингээдэг хүний эрүүл ходоодыг зүйрлэн хэлэлцдэг байсан бол одоо ходоод гэдэсний өвчинд зовж зүдэрсэн ч арга чадалтай зарим нь чоно алж, ходоодыг нь халуун бүлээнээр нь түүхийгээр идэж, өвчин зовлонгоосоо илааршиж чаджээ. Бас чонын шагай зүүх, арьс үсийг нь ашиглах, ер чоноос хаях юм байхгүй болохоор 1990—ээд оны эхнээс “хөлдүү чонын мах” авна гэх мэтээр хэвлэл мэдээллээр зар сурталчилгаа үлэмж явагдаж, чухам тэр үеэс нэг ёсондоо чонотой дайтаж, эдүгээ тоо толгой нь ихээхэн цөөрчээ.

2. Чоно бол “ижил тэнгэртэйдээ харагдаж, илүү тэнгэртэйдээ алагдана” гэсэн амтай хэмээдэг ч үлэмж хийморлог амьтан.

Монголчууд байгаль орчноо сайн танин мэдэж, зөв зохистой ашиглаж, өсөлт хөгжилтийн үе шатыг нь онцгой анхаарч, бас хайрлан хамгаалах талаар ч өвөрмөц арга туршлагыг хуримтлуулж ирсэн байна. Энэ бол байгаль экологийн жам ёсны хууль зүй тогтлыг амьдралынхаа бүх үеийн туршид ердийн ажиглалт, туршилтын явцад нүүдэлчин малчид маш сайн ойлгож, өөрсдийнхөө эрх ашгийн дагуу зөв зохистой харгалзан үзэж ирснийг нотлож бүхий хэмээн хэлж болно. Монгол анчид ан амьтныг агнахаас гадна тэдгээрийг сайтар судлаж, өсөлт хөгжилтийн үе шатыг нь сайн мэддэг, аль улиралдагнавал зохихыг зохицуулдаг арга туршлагатай юм. Энэ учраас чоныг маш их ажиглаж, ааш занг хүртэл мэддэг болсон байна. Чоно бол маш муу санаатай, өдөр нь амарч, шөнө гөрөөлдөг, идэш тэжээлээ олохын тулд их тэнүүчилж явдаг хашир араатан билээ. Чоныг хөөж агнахад сугарч

³ Ганболд.М, Пүрэв.Г, *Амьтан судлал*, УБ, 2013, 170.

үлдэх, аль болох саад бартаатай газарт зугатаж очих зэргээр янз бүрийн хашир башир арга зальтай гэдэг. Энэ бол амьтны биеэ хамгаалах нэгэн чадвар бололтой юм. Бас чонын улих дуучимээ тун нарийн утга учиртай ажээ. Ороо нь орсон үед болон идэш тэжээл олсон цагт чононууд бие биедээ чимээ өгөхөөс гадна аюул тохиолдсон үедулих нь өөр, өөр хэмээн хашир анчидярьдаг. Тиймээс ахмад хашир анчид тэр дуучимээг нь дуурайж улихад чоно тэрэнд хууртагддаг тал бий гэнэ. Энэ нь монгол анчдын ан агнуурын нэг өвөрмөц арга байв.

Чонын мах нь малынхаас нэг их ялгагддаггүй боловч монголчууд чонын мах идэхийг цээрлэдэг байжээ. Учир нь хэрэв чонын махыг хүн идвэл нас барсан хойноо төрлөө олохгүй гэж үздэгтэй холбоотой ажээ.

Чоно бол “малын дайсан”, их муу санаатай, сүйтгэлтэй араатан хэрнээ бизнесийн ашиг орлого сайтай амьтан. Нүүдэлчин малчид үеэс үед дамжин, малаа чононд идүүлнэ гэдэг бол эзний муугийнх гэж үзэж иржээ. Сайн хариулга маллагаатай малыг чоно яаж идэж чадах билээ гэдэг. Энэ бол маргашгүй үнэн, бас их сургамжтай үг юм.

Оросын академич И. М. Майский бичихдээ, “Монголд чононууд үнэхээр олон, ялангуяа олноороо цугласан I, II сардонцгой аюултай. Энэ үед чононууд малын мөрөөр мөрдөж, шөнө төдийгүй, өдрөөр адуу мал руу дайрч сүйтгэл учруулдаг. Хангальцах голын эрэгт байсан манай өвөлжөө рүү 10-12 чоно дайрч, манай экспедицийн нэг сайн морийг барьж идсэн. Чононууд жинхэнэ бич байсан. Иймээс жилд хэдэн арав, хэдэн зуун мянган хонь, үхэр, адуу, тэмээ тэдний хоол болж байжээ. Төл мал бол эдгээр зэрлэг араатны хоол болж байсан. Чонын дайралт бол монголын мал аж ахуйн байнгын дайсан байлаа” гэжээ⁴. Энэ ажиглалт нь чонын сүргийг муугүй судалсантай холбогдож байсан гэж үзэх үндэстэй. Учир нь чоно бол өвөл сүргээрээ явж, идэш хоол эрэхээс гадна ороо нь орж мал амьтан, бүр хүн рүү халддаг байна. Иймээс хөдөө орон нутгийн хүмүүс боохой ширүүслээ хэмээн хэлдэг. Манай оронд жил бүрийн хавар чонын бэлтрэг суйлах ажил явагддаг байв. Энэ үед чонын үүр хайж, дөнгөж нүдээ нээсэн гөлгийг устгах нь чонын тоо толгойг цөөлөх ач холбогдолтой байжээ. Чонын үүрнээс бэлтрэг суйлахад бас анхаарах зүйл байдаг ажээ. Юуны өмнө үүрэнд байгаа бүх бэлтрэгийг толгой дараалан устгаж болохгүй. Яагаад гэвэл, үүрэнд байгаа 7-11 бэлтрэгийн 2-ыг үлдээхгүй бол чоно бэлтрэг суйлсан хүмүүсийг үнэрээр нь мөрдөн ихээхэн хохирол учруулдаг гэдэг. Энэ нь бас хүн байгалиас бүх хишгийг нэг мөсөн цөлмөж болохгүй, ан амьтныг ч хайрлан, өсөж үржих үндсийг нь бүрмөсөн таслахгүйг хичээж ирсэн уламжлалтай холбоотой байна.

Ер нь “Тоо толгой олширсон үед мэрэгчдийн хувьд тодорхой хөнөөл учруулдаг нь бэлчээрийн доройтлын асуудлаар илэрч байна. Дээхэн үед дэлхийн

⁴ Майский, И. М. *Монголия накануне революции*, Москва, 1960, 122-123.

улс орнууд агнуурын буюу үслэг ан, махны чиглэлээр олон төрөл зүйл махчин амьтад, тууртан амьтдыг зохион байгуулалттай агнаж ирсэн бол эдүгээ түүх болон үлджээ. Орчин үед хөхтөн амьтад, ялангуяа агнуурын гэгдэх том болон дунд зэргийн биетэй амьтад тоо толгой нь эрс цөөрч, ховордсоор байна.”⁵

Зөвлөлтийн үеийн судалгаагаар, нэг чоно жилд гурван тонн мах буюу 150 толгой мал иддэг гэсэн тооцоо гарчээ. Бас домогтөгүүлэхдээ, бурхан хамаг амьтдад хувь өмч хуваахдаа чоныг мартсан учраас “зуун толгой амьтнаас чи өөрийн хүчээр нэгийг барьж ид” гэснийг нь зуун толгой амьтнаас нэгийг үлдээгээд бусдыг нь цөмийг барьж ид гэж чоно сонссон ажээ. Тийм учраас идэхгүй ч гэсэн олон амьтныг сэглэж, сүйтгэдэг байна. Монголчууд чоныг эрт дээр үеэс янз бүрийн аргаар агнаж ирсэн. “1900 оны үеэс эхлэн хор их тавих болсноос хойш чоно бага зэрэг цөөрч, 1909 онд 1 бум 2 түм 1 мянга 400 (121400) чонын арьс, 1908 онд Чуулалт хаалгаар 2 түм, Хиагтаар 1314 чононы арьс тус тус гадаадад гаргаж байсан. Манай оронд зөвхөн 1929-1930 оны өвөл 4000 тэмээ, 23000 адуу, 22000 үхэр, 177000 хонь, 28000 ямаа, бүгд 254000 толгой малыг чоно иджээ. Гагцхүү Сэлэнгэ аймаг 1932-1933 оны өвөл чоно идсэн мал 5210 хүрсний дотор тэмээ 1, адуу 586, үхэр 296, хонь, ямаа 4327 болж байв. 1935 онд гаргасан мэдээгээр, чоно жил тутам дундажаар бог мал 2 бум, бод мал 2 түм хэрийг иддэг байжээ” гэж О. Намнандорж номондоо бичжээ⁶.

Монголын түүхийн ном зохиолуудад буй “зээгтав”, “хайдаг ав”, “чонын ав”, “ав тавихуй”, “ангийн төв” гэсэн нэр томъёонууд нь манай оронд эрт үеэс ан авын ажил уламжилж ирснийг нотлож байна. Эдгээрээс заримыг нь товч тодруулбал, “... чоно араатны аюул довтолгоон улам ширүүсэх ахул доогуур нь түүний хөл хорих “гал нурман зээг”, дээгүүр нь толгой хүзүүг урхидан гогодох “дээсэн зээг” тус тус хослуулан татна. Түүнийг “хотны давхар зээг” хэмээнэ. Энэ нь нэлээд найдвартай арга бөгөөд учир нь харанхуй шөнө халуун нурман дээр ул тавхайгаараа гишгэх буюу эсхүл хүзүү омруугаараа урхидуулж гогодуулсан зэрлэг амьтан хэдий улангассан атугай ч хариу буцаж зайлах нь зайлшгүй болой⁷” гэжээ. Энэ нь бас нийт монголчуудын нэг өвөрмөц зан үйлийн үндэс болсон бололтой. Тэр нь юухэмээхүл, монголчууд чоно болон бэлтрэг агнасны дараа нарийн гэдсээр нь явсан зам дээрээ хэц татаж орхидог, энэ нь бусад нь араас мөрдөж ирвэл түүн дээр тээглээд буцна гэж үзэж хор хөнөөл хүргэхээс хамгаалсан зориулалттай зан үйл юм. Манай хөдөө орон нутагт зарим хүмүүс ахуй амьдралын хамгийн энгийн зүйл дээр ч бас дом шившлэгийн зан үйлийг баримталж ирсэн байдаг. Жишээ нь, үйлний хайчны амыг боогоод, Чи чулуун тарни, чамайг даасан тарни, араа зүрийн тарни, араатныг даасан тарни гэж хэлдэг байжээ. Энэ нь хонь

⁵ Ганболд, М, Пүрэв, Г, *Амьтан судлал*, УБ, 2013, 176.

⁶ Намнандорж, О, *БНМАУ-ын дархан газар, ан амьтад*, УБ, 1964, 102.

⁷ Гонгор, Д, *Халх товчоон II*, УБ, 1978, 356.

малаа чононоос хамгаалж үйлдэж буй домын чанартай зан үйл мөн билээ. Мөн “Ойрад монголчуудын дунд чоно алаад, бууны дарины үнэр гараагүй үед аманд нь бууны амаа хийдэг заншил байжээ. Бас чоно алаад хүзүүгээр нь оосорлоод 3- 4 метр газар чирч, “чамайг би алаагүй, чи боож үхлээ” гэж хэлдэг байна.”⁸ Энэ бүхнээс үндэслэж, малчин түмэн хороо хотныхоо гадуур дээс, олс, төмөр утас зэрэг нарийн зүйлээр намхан тойрог хэц татах уламжлал бий болсон нь малаа чоноос хамгаалсан нэг арга байжээ. Ер нь ахмадууд чоно бол олс дээсэн дээгүүр давж малд халддаггүй хэмээн ярьдаг.

Манай анчин өвөг дээдэс анд мордохын өмнө ерөөл дэвшүүлэхдээ,

Түг түмэн гөрөөсний эзэн манхан тэнгэр минь
Ороо догшин гөрөөсдөө, олом жирэмний доогуур оруулагч манхан тэнгэр минь
Өчүүхэн миний өчгийг сонсож соёрхоно уу.
Өндөр дээд тэнгэр, өргөн эх алтан дэлхий
Өгөөмөр баян алтай хангай нутаг минь, өвөртөө оршигч
Өлгийдөө бэлчигч буга, согоо, булга, шилмүүс
Хөх чоно, хөндийн гөрөөс, хадны ирвэс, модны хэрэм
Хамаг ан гөрөөнийхөө хишгийг өгөн соёрхоно уу

гэж тахилга цацал, өчил даллага өргөж байжээ.

Алтайн анчдад бас үнэг, чоно алаад хоншоорыг нь өвчиж дуусаагүй байхад ирсэн хүн олзны хуваарьт орж арьсыг нь худалдсаны дараа авсан зүйлээс нь хуваалцдаг ёс байжээ⁹.

Өнөө хэр цаг үе нөхцөл байдал өөрчлөгдөж, ан агнуурын ажлын чиг зорилго ч ихээхэн өөр болсон учраас чонын хөөлгө гэдэг нь түүх болон үлдэж, харин байгаль хамгаалах үүднээс чоныг хавтгайруулан алах биш, бас байгалийн зохицолдлогооны талаас нь аврах, тодорхой хэмжээгээр хамгаалах шаардлага ч зүй ёсоор тавигдаж байна гэж үзэж болох билээ. Энэ бүхнээс үндэслэж, дараах зарим санал дүгнэлтэнд хүрч байна.

Дүгнэлт, санал

Байгалийн олон төрөл зүйл ан амьтдын дотор чоно бол ихээхэн хийморлог, хүчирхэг хэмээгдэж, зарим үед хараал ерөөлд хүрч, заримдаа алж устгаж, тоо толгойг нь цөөрүүлж иржээ. Энэ өгүүлэлд, чонын хөөлгө гэдэг нэгэн кампанит ажлын талаар товчхон хөндлөө. Энэ нь зөвхөн чоныг хамгаалах биш, ерөнхий утгаараа байгаль хамгаалалын нэг салшгүй хэсэг гэдгийг зориуд тэмдэглүүштэй.

Чоно бол амьд байгалийн цэвэрлэгч, байгалийн шалгарлын хуулиар өсөж

⁸ Батмөнх, Б. *Монголчуудын уламжлалт ан ав (XIX-XX зууны зааг дахь Ойрад Монголчуудын жишсэн дээр)* УБ., 2005, тал 149.

⁹ *Монгол улсын угсаатны зүй, 2 боть* УБ, 1996, 288.

үржиж, үхэж хорогдож ирсэн нэгэн зүйл амьтан юм. Хүн байгалийн жам ёсны хууль зүй тогтлыг сайн ойлгодог хэрнээ байгалийн тэнцвэрт харьцааг алдагдуулсан зарим үйлдлийг урьдмөн ч гаргаж байсан, эдүгээ ч гаргаж байна. Малын дайсан чонотой ширүүн тэмцэл явуулж байсан үе байв. Тэр үед чонын үргээлэг, хөөлгө, бэлтрэг суйлах зэрэг олон арга хэмжээ авч байсан ч монголд чоноо бүрэн устгаагүй билээ. Тухайн үед монгол анчид ан амьтдыг хамаагүй алж устгадаггүй, зохих ёс журмыг баримталж, байгаль хамгаалах өвөрмөц арга барилтай байжээ. Өнөө үед тэр бүхнээс санаа сургамж авах зүйл тун их. Малаа чононд оруулсан малчныг муу малчин, арчаагүй этгээд хэмээн үзэж ирсэнтэй бид санал нэг байна. Учир нь хариулга сайтай мал сүргийг чоно эргэж, дайрч сүйтгэл учруулж чадахгүй, чоно ч бас амьдрахын төлөө зүтгэж байгаа амьтан болохоор түүнд бүх бурууг тохож болохгүй.

Өнөө үед чоно бол магадгүй амар хялбар аргаар ашиг олох нэг хэрэгсэл болж, алж устгах ажлыг хамаагүй хавтгайруулж, хайрлаж хамгаалах гэдэг үндсэндээ орхигдсон бололтой юм. Иймээс зарим орон нутагт, ялангуяа дорнод монголын саарал чонын тоо толгой ихээхэн цөөрч, одоо түүнийг хамгаалах талаар их яригдаж байна. Гэтэл хангайн бүсэд чоно их өсөж, мал сүрэг рүү байнга дайрч, чоно авлах тухай яриа сүүлийн үед гарах боллоо. Энэ учраас чоныг хамгаалах, алж устгах тухай үзэл бодол, үйл хэрэг яг зэрэгцэж байна гэж үзүүштэй. Иймээс бид дараах зарим санал дүгнэлт хийхийг оролдлоо. Үүнд,

- Монголчууд бид бүхэн байгалиас асар их зүйлийг авч байгаа хэрнээ, өгч байгаа нь үнэхээр чамлалттай мэт. Иймээс юуны өмнө чоно гэдэг араатны талаар манай хүмүүс, ялангуяа хүүхэд залуучуудад үнэн зөв, бодиттой ойлголт өгөх хэрэгтэй болов уу. Зарим нь чоныг биетээр нь ч хараагүй, мэдэхгүй шүү дээ. Тэр үндсэн дээр чоноо алж устгах уу, бас хамгаалж үлдээх үү гэдгээ хойч үе маань шийдэх буй за.
- Манай оронд явагдаж ирсэн чонын үргээлэг, хөөлгө бол тухайн цаг үедээ мал сүргээ хамгаалах нэг арга болж байжээ. Өнөө үед энэ нь үндсэндээ түүх болж үлдсэн юм. Гэвч түүнээс санаа сургамж авах зүйл үлэмж байна. Хэрэв чонын тоо толгой ихээхэн нэмэгдвэл хүн, малыг халдлагаас хамгаалах хамгийн энгийн арга ч бас хэн бүхэнд хэрэгтэй билээ. Ялангуяа хангайн бүсэд чоно их өсвөл тодорхой бүс нутагт, хязгаарлагдмал байдлаар чоно алж, хүн малаа хамгаалахад буруу зүйл байхгүй юм.
- Чоно бол амьд байгалийн цэвэрлэгч, тэнцвэрт байдлыг хадгалагч гэсэн утгаар нь цаашдаа бүрэн устгах биш, бизнесийн нэг хэрэгсэл болгох биш, орон нутагт маш сайн хяналттай, өсөж үржих боломжийг нь тодорхой хэмжээгээр хангаж өгвөл зүйтэй бус уу хэмээн үзэж байна.

Энэ бүхнийг эш үндэс болгож, монголчуудын байгаль хамгаалах нарийн арга ухаанаас бид цаашид их суралцах, өнөөгийн нөхцөл байдалд шинэчлэн

баяжуулж хэрэглэх явдал зайлшгүй чухал гэж үзэхийн сацуучоно бол манай экосистесийг бүрдүүлэгч нэг салшгүй хэсэг учраас түүнийг сайтар судлах, таньж мэдэх, хамгаалах асуудлыг төрийн бодлогын үндсэн дээр хэрэгжүүлэх хэрэгтэй юм. Чухам энэ санааг тодотгож, уг асуудлыг товчхон хөндсөн маань энэ бөлгөө. Байгаль орчноо хайрлан хамгаалцгаая.

Abstract: This article proposes to raise and solve the issue of better investigation, understanding and protection of wolves on the basis of the state policy due to the vital fact that they are inseparable part of our ecosystem, while it points out that it is necessarily important for us not only to learn the Mongolians' sophisticated knowledge and methods of preserving the natural environment, but also to enrich and apply them in the current situations.